

КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫГ СОНГОН
ШАЛГАРУУЛАХ, НЭР ДЭВШҮҮЛЭХ, ТОМИЛОХ, ЧӨЛӨӨЛӨХ ЖУРАМ

Т1-ТУЗ-02

“Монлөжистикс Холдинг” ХК-ийн Төлөөлөн
Удирдах Зөвлөлийн 2024 оны 03 сарын 12-ны өдөрнийн
24/ТУЗ/13 тоот тогтоолын №1 дүгээр хавсралтадар бий.

МОН ЛӨЖИСТИКС ХОЛДИНГ ХК

АТА11138_6381251
9023121052

КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН
ТУШААЛТНЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ, НЭР
ДЭВШҮҮЛЭХ, ТОМИЛОХ, ЧӨЛӨӨЛӨХ ЖУРАМ

Баримт бичгийн дугаар
[Т1-ТУЗ-02]

АГУУЛГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	3
ХОЁР. ЭРХ БУХИЙ АЛБАН ТУШААЛТАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА	3
ГУРАВ. ШААРДЛАГА ХАНГАСАН ЭСЭХИЙГ ТОДОРХОЙЛОХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	4
ДӨРӨВ. ШАЛГУУР ХАНГАСАН ЭСЭХИЙГ ТОДОРХОЙЛОХ	5
БАРИМТ БИЧГИЙГ БҮРДҮҮЛЭХ	5
ТАВ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ, НЭР ДЭВШҮҮЛЭХ, ТОМИЛОХ	6
ЗУРГАА. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНЭЭС БУСАД КОМПАНИЙН ЭРХ БУХИЙ АЛБАН ТУШААЛТНЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ, ТОМИЛОХ	7
ДОЛОО. КОМПАНИЙН ЭРХ БУХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ	8
ҮҮРГИЙГ ХУГАЦААНААС ӨМНӨ ДУУСГАВАР БОЛГОХ	8
НАЙМ. КОМПАНИЙН ЭРХ БУХИЙ АЛБАН ТУШААЛТНЫГ ТҮР ТОМИЛОХ, ЗАЛГАМЖ ХАЛААГ БЭЛДЭХ	8
ЕС. ТОХИРОМЖТОЙ ЭТГЭЭДИЙН ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА	9
АРАВ. БУСАД	10
АРВАН НЭГ. ХОЛБОГДОХ БАРИМТ БИЧГҮҮД	10
БАТАЛГАА	11
(ТУЗ-ийн хараат бус гишүүдээс бусад эрх бүхий албан тушаалтан)	11
БАТАЛГАА	12
(ТУЗ-ийн хараат бус гишүүн)	12
МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХК-ИЙН ТУЗ-ИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙН АНКЕТ	14
НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ	17

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. “Компанийн эрх бүхий албан тушаалтныг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам” (цаашид “Журам” гэх)-ын зорилго нь “Монложистикс Холдинг” ХК (цаашид “Компани” эсхүл “Толгой компани” гэх), түүний охин компанийн эрх бүхий албан тушаалтанд тохиромжтой этгээдийг тодорхойлох, эрх бүхий албан тушаалтныг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх, нөөцөд бүртгэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Компанийн эрх бүхий албан тушаалтны орон тоо, тэдгээрийн залгамж халааны бодлого нь Компанийн хэвийн, тогтвортой, тасралтгүй үйл ажиллагааг хадгалах, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч болон бусад оролцогч талуудын эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөхгүй байх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэнэ.
- 1.3. Компанийн залгамж халааг бэлтгэх, эрх бүхий албан тушаалтанд тохиромжтой этгээдийг сонгохтой холбоотой харилцаанд хууль дээдлэх, шударга, ил тод байх, компанийн эрх ашгийг дээдлэх, тасралтгүй байх зарчмыг баримтална.
- 1.4. Компани нь эрх бүхий албан тушаалд дэвшүүлэх ажилтны ур чадварыг хөгжүүлэх, сурган бэлтгэх төлөвлөгөөг боловсруулах ба хэрэгжүүлэх, үнэлж дүгнэх замаар залгамж халааны бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.5. Энэхүү журам нь Толгой компани болон түүний охин компанийн эрх бүхий албан тушаалтныг сонгон шалгаруулахтай холбоотой харилцаанд нэгэн адил үйлчилнэ.
- 1.6. Охин компани нь Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан дүрэм, журам, заавар, Компанийн дүрэм болон энэхүү журамд нийцүүлэн эрх бүхий албан тушаалтныг сонгон шалгаруулах, томилох, залгамж халааг бэлтгэхтэй холбоотой харилцааг нарийвчилсан байдлаар зохицуулсан дотоод баримт бичгийг батлан, мөрдөж болно.
- 1.7. Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
 - 1.7.1. “Эрх бүхий албан тушаалтан” гэж Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1- болон Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.1-т заасныг;
 - 1.7.2. “Тохиромжтой этгээд” гэж Үнэт цаасны тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1-т заасныг;
 - 1.7.3. “Нэгдмэл сонирхолтой этгээд” гэж Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.2-т заасныг;
 - 1.7.4. “Охин компани” гэж тухайн компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 50-аас дээш хувийг өөр компани эзэмшдэг бие даасан компанийг;
 - 1.7.5. “Хороо” гэж ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороог;

ХОЁР. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 2.1. ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо (цаашид “Хороо” гэх) нь дараах ерөнхий шаардлагыг хангасан этгээдийг Компанийн эрх бүхий албан тушаалтанд нэр дэвшүүлэхэд тохиромжтой этгээд гэж үзнэ. Үүнд:
 - 2.1.1. Мэдлэг боловсрол, ажлын туршлага, мэргэжлийн ур чадвартай байх;
 - 2.1.2. Гэмт хэрэгт холбогдож байгаагүй;
 - 2.1.3. Бизнесийн болон ёс зүйн зөрчилгүй, зан суртахууны доголдолгүй байх;

**КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫГ СОНГОН
ШАЛГАРУУЛАХ, НЭР ДЭВШҮҮЛЭХ, ТОМИЛОХ, ЧӨЛӨӨЛӨХ ЖУРАМ**

Т1-ТУЗ-02

- 2.1.4. Шууд өрсөлдөх үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжид өөрөө, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь хувьцаа эзэмшдэггүй, эрх бүхий албан тушаалтнаар ажилдаггүй байх;
- 2.1.5. Хууль тогтоомж болон Компанийн дүрмээр тодорхойлсон бусад шаардлага.
- 2.2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн хараат бус гишүүн нь журмын 2.1-т заасан ерөнхий шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - 2.2.1. Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны таваас дээш хувийг эзэмшдэггүй;
 - 2.2.2. Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэггүй, эсхүл сүүлийн 3 жилийн хугацаанд ажил, албан тушаал эрхэлж байгаагүй;
 - 2.2.3. Төрийн үлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй;
 - 2.2.4. Компанитай бизнесийн аливаа холбоогүй.
- 2.3. Компанийн эрх бүхий албан тушаалтны ажлыг түр орлон гүйцэтгэх этгээдэд Журмын 2.1-т заасан ерөнхий шаардлага нэгэн адил тавигдах ба түр гүйцэтгэх этгээд нь ТУЗ-ийн гишүүний оронд түр томилогдох тохиолдолд хараат бус гишүүний шаардлагыг давхар хангасан байна.
- 2.4. Охин компанийн эрх бүхий албан тушаалтан нь Журмын 2.1-т заасан шаардлагыг хангасан этгээд байна.

ГУРАВ. ШААРДЛАГА ХАНГАСАН ЭСЭХИЙГ ТОДОРХОЙЛОХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

- 3.1. Журмын 2.1.1-т заасан шаардлага хангаж байгааг дараах үзүүлэлтүүдээр тодорхойлно.
Үүнд:
 - 3.1.1. Санхүү, бизнесийн удирдлага, эдийн засаг, нягтлан бодох бүртгэл, хөрөнгө оруулалт, тээвэр ложистик, мэдээллийн технологи, математик, статистик, инженерчлэл, компанийн засаглал, хууль, эрх зүйн чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх;
 - 3.1.2. ТУЗ-ийн гишүүд болон Гүйцэтгэх удирдлагад нэр дэвших этгээд нь мэргэжлээрээ эрх бүхий албан тушаалтнаар 4 ба түүнээс жил ажилласан эсхүл 3.1.1-т заасан чиглэлээр 7 ба түүнээс дээш жил ажилласан туршлагатай байх;
 - 3.1.3. 3.1.2-т зааснаас бусад эрх бүхий албан тушаалтанд нэр дэвших этгээд нь мэргэжлээрээ эрх бүхий албан тушаалтнаар 2 ба түүнээс жил ажилласан эсхүл 3.1.1-т заасан чиглэлээр 5 ба түүнээс дээш жил ажилласан туршлагатай байх
 - 3.1.4. ТУЗ-ийн бүтэц бүрэлдэхүүн, үйл ажиллагаанд жил бүр үнэлгээ хийх замаар ТУЗ-ийн гишүүдийн мэдлэг боловсрол, ур чадвар, туршлага нь компанийн стратегийн зорилго зорилтыг оновчтой тодорхойлох, хэрэгжилтэнд хяналт тавихад хувь нэмэр оруулахуйц байгаа эсэхэд хяналт тавьж шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах саналыг ХЭХ-д дэвшүүлнэ.
 - 3.1.5. ТУЗ-ийн гишүүн, нарийн бичгийн дарга болон Гүйцэтгэх удирдлагад нэр дэвших этгээд нь Компанийн засаглалын чиглэлээр холбогдох байгууллагаас зохион байгуулсан сургалтад сууж гэрчилгээ авсан байх.
- 3.2. Журмын 2.1.2-т заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг дараах үзүүлэлтээр тодорхойлно.
Үүнд:
 - 3.2.1. Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаал, эдийн засгийн болон терроризм, үй ольоор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, тэдгээрийг санхүүжүүлэх, хуурамч баримт бичиг

үйлдэх, ашиглах гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээгээгүй, эсхүл хүлээж байгаагүй байх;

- 3.2.2. Журмын 3.2.1-т заасан гэмт хэрэгт хариуцлага хүлээж байгаагүй ч нэр дэвшихээс өмнө 6 ба түүнээс доошгүй сарын өмнө дээрх гэмт хэргүүдэд холбогдуулан шалгагдаж байгаагүй байх.
- 3.3. Журмын 2.1.3-т заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг дараах үзүүлэлтээр тодорхойлно.
Үүнд:
- 3.3.1. Монгол Улсын болон гадаад улсын нутаг дэвсгэрт сүүлийн хоёр жилийн хугацаанд бизнесийн ёс зүйн хэм хэмжээг зөрчөөгүй байх;
- 3.3.2. Хугацаа хэтэрсэн өр зээлгүй, шүүхийн шийдвэрээр хүлээсэн өр төлбөргүй байх;
- 3.3.3. Монгол Улсын болон гадаад улсын нутаг дэвсгэрт зохицуулалтын аливаа шаардлага, мэргэжлийн болон ёс зүйн аливаа стандартыг дагаж мөрдөхөө бичгээр илэрхийлсэн байх;
- 3.3.4. Нэр дэвшихээс сүүлийн өмнө сүүлийн 2 жилийн хугацаанд хууль тогтоомж, Компанийн бодлого, төлөвлөгөө, дүрэм, Хөдөлмөрийн дотоод журам, Хөдөлмөрийн гэрээ, ёс зүйн хэм хэмжээнд заасан зөрчил гаргаж, улмаар ажил үүргээсээ ажил олгогчийн санаачилгаар чөлөөлгөөгүй, бүрэн эрх дуусгавар болоогүй байх.
- 3.4. ТУЗ-ийн хараат бус гишүүнээс бусад Компанийн эрх бүхий албан тушаалтанд нэр дэвшигч нь өөрийн гаргасан баримт бичиг, мэдээллийг үнэн зөвийг, Монгол Улсын болон гадаад улсын нутаг дэвсгэрт зохицуулалтын аливаа шаардлага, мэргэжлийн болон ёс зүйн аливаа стандартыг дагаж мөрдөхөө баталж, журмын Хавсралт №1-р батлагдсан Т1-ТУЗ-02-М1 маягтын дагуу бичгээр баталгаа гаргана.
- 3.5. Хараат бус гишүүний хувьд журмын 3.4-д заасныг баталгаажуулан Хавсралт №2-р батлагдсан Т1-ТУЗ-02-М2 маягтын дагуу бичгээр баталгаа гаргана.
- 3.6. ТУЗ-ийн гишүүн болон Гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлийн үнэлгээ 2 жил дараалан хангалтгүй буюу 80%-иас доош үнэлгээтэй гарсан тохиолдолд тухайн албан тушаалтныг Журмын 2.1.1-т заасан шаардлагыг хангаагүй гэж үзнэ.

ДӨРӨВ. ШАЛГУУР ХАНГАСАН ЭСЭХИЙГ ТОДОРХОЙЛОХ БАРИМТ БИЧГИЙГ БҮРДҮҮЛЭХ

- 4.1. ТУЗ-ийн гишүүний болон нарийн бичгийн даргын сонгон шалгаруулалтад оролцохыг хүссэн этгээд нь дараах баримт бичгийг үнэн зөв, бүрэн гүйцэт бүрдүүлэн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга эсхүл ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороонд ирүүлнэ.

Үүнд:

- 4.1.1. Анкет /Хавсралт №3-р батлагдсан Т1-ТУЗ-02-М3 маягт/;
- 4.1.2. Боловсролын дипломын хуулбар;
- 4.1.3. Бусад шаардлагатай сургалтад суусныг нотлох баримт;
- 4.1.4. Нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалт /Хавсралт №3-р батлагдсан Т1-ТУЗ-02-М4 маягт/;
- 4.1.5. Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь шууд өрсөлдөх үйл ажиллагаа явуулах аж ахуй нэгжид хувьцаа эзэмшдэггүй, эрх бүхий албан тушаалтнаар ажилдаггүйг нотлох баримт;
- 4.1.6. Ажилласан байдал, туршлагын талаар нотлох баримт;
- 4.1.7. Зээл, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй болохыг нотлох баримт бичиг;
- 4.1.8. Шүүхийн шийдвэрээр хүлээсэн аливаа үүрэг, өр төлбөргүй болохыг нотлох баримт;
- 4.1.9. Гааль, татварын өр, төлбөргүй болохыг нотлох баримт бичиг;

- 4.1.10. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа, гэмт хэрэгт оролцож байгаагүй болохыг нотлох баримт бичиг;
- 4.1.11. Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа болон байсан эсэхийг нотлох баримт;
- 4.1.12. Журмын Хавсралт №1 эсхүл №2-т заасан баталгаа /аль тохирихыг/.
- 4.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үйлдэл, эс үйлдэхүй гаргахыг хориглох ба тус үйлдэл, эс үйлдэхүй гаргасан нь тогтоогдсон тохиолдолд нэр дэвшигчээр бүртгэх, эрх бүхий албан тушаалтнаар сонгохыг хориглоно. Үүнд:
 - 4.2.1. Компанийн эрх бүхий албан тушаалтанд тавих шаардлагыг хангах зорилгоор хуурамч бичиг баримт бүрдүүлсэн, худал ташаа, дутуу мэдээлэл өгсөн;
 - 4.2.2. Өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээллийг нуун дарагдуулсан;
- 4.3. Журмын 4.2-т заасан үйлдэл, эс үйлдэхүй гаргасан нь хожим тогтоогдсон тохиолдолд Эрх бүхий албан тушаалтантай байгуулсан гэрээг Компанийн санаачилгаар цуцлах үндэслэл болно.
- 4.4. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь эрх бүхий албан тушаалтныг тохиромжтой этгээд болохыг нотлох баримтуудыг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлнэ.

ТАВ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ, НЭР ДЭВШҮҮЛЭХ, ТОМИЛОХ

- 5.1. ТУЗ-ийн гишүүдийг сонгон шалгаруулах, хувьцаа эзэмшигчдийн хуралд нэр дэвшүүлэх ажлыг ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо зохион байгуулна.
- 5.2. ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруулалтыг дараах үндэслэлээр зарлана. Үүнд:
 - 5.2.1. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон;
 - 5.2.2. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох ХЭХ-ын шийдвэр гарсан;
 - 5.2.3. ТУЗ-ийн нийт гишүүдийн 50-аас дээш хувь нь ажиллах боломжгүй буюу ажиллахгүй болсон;
 - 5.2.4. Энэхүү журам болон хууль тогтоомжид заасан бусад үндэслэл бий болсон.
- 5.3. ТУЗ-ийн гишүүдийг кумулятив аргаар сонгох бөгөөд энэ тохиолдолд ТУЗ-ийг зөвхөн бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас өмнө бүрэн эрхийг нь дуусгавар болгож болно.
- 5.4. Журмын 5.2-т заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд ТУЗ нь ХЭХ хуралдуулах тухай шийдвэр гаргах ба хурлыг Компанийн “Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах журам”-ын дагуу зохион байгуулна.
- 5.5. ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах зарыг нийтэд нээлттэй зарлах ба тус зард сонгон шалгаруулалтын материал хүлээн авах эцсийн хугацаа, бүрдүүлэх материал, тавигдах шаардлага болон бусад сонгон шалгаруулалттай холбоотой журмыг нарийвчлан заасан байна.
- 5.6. Журмын 5.5-д заасан сонгон шалгаруулалтын материал хүлээн авах эцсийн хугацааг хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах өдрөөс ажлын 20-оос доошгүй хоногийн өмнө байхаар тогтоох ба Хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах комиссын дарга эсхүл ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь хувьцаа эзэмшигчдийг ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулгатай танилцах боломжоор хангаж ажиллана.
- 5.7. ТУЗ-ийн гишүүн аливаа шалтгааны улмаас ажиллах боломжгүй болсон ба нөхөн сонгууль хүртэл ТУЗ-ийн гишүүнийг түр томилох шаардлагатай болсон тохиолдолд ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо сонгон шалгаруулалт зарлаж болно.

**КОМПАНИЙН ЭРХ БУХИЙ АЛБАН ТУШААЛТНЫГ СОНГОН
ШАЛГАРУУЛАХ, НЭР ДЭВШҮҮЛЭХ, ТОМИЛОХ, ЧӨЛӨӨЛӨХ ЖУРАМ**

Т1-ТУЗ-02

- 5.8. Саналын эрх бүхий энгийн хувьцааны тав буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч ТУЗ-ийн гишүүнд хүн нэр дэвшүүлж байгаа тохиолдолд энэ талаарх саналаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулахаар сонгуульт жилийн өмнөх санхүүгийн жил дууссанаас хойш 60 хоногийн дотор эсхүл сонгон шалгаруулалтын материал хүлээн авах эцсийн хугацааны дотор ТУЗ-ийн нарийн бичгийн дарга эсхүл гүйцэтгэх удирдлагад гаргаж болно.
- 5.9. Хувьцаа эзэмшигч нь Журмын 5.8-д заасан саналаа бичгээр гаргах ба саналд хараат бус гишүүн, ердийн гишүүний аль нь болох, санал оруулж байгаа хувьцаа эзэмшигчийн эцэг/эх-/ийн нэр, өөрийн нэр, түүний эзэмшлийн хувьцааны төрөл, тоог тусгахаас гадна нэр дэвшүүлэх этгээд нь хууль тогтоомж болон энэхүү Журмаар тогтоосон ТУЗ-ийн гишүүний шалгуурыг хангаж байгааг нотолсон баримт бичгийг хавсаргасан байна.
- 5.10. Гүйцэтгэх удирдлага, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь Журмын 5.8-д заасан саналыг хүлээн авсан тохиолдолд сонгон шалгаруулалтын баримт бичгийг ажлын гурван өдөрт багтаан ТУЗ-д албан ёсны и-мэйл хаягаар хүргүүлнэ.
- 5.11. ТУЗ нь Журмын 5.8-д заасан саналыг Компанийн тухай хуульд заасан нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах үндэслэл байхгүй бол хүлээн авснаас ажлын 10 хоногийн дотор хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалд оруулах, нэр дэвшигчид бүртгэх үргийг хүлээнэ.
- 5.12. ТУЗ нь Компанийн тухай хуульд заасан үндэслэлээр саналыг ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулах, нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсан бол энэ тухай үндэслэл бүхий тайлбарыг шийдвэр гаргаснаас хойш ажлын гурван өдрийн дотор санал гаргасан хувьцаа эзэмшигчид хүргүүлнэ.
- 5.13. ТУЗ-ийн гишүүнийг улируулан сонгох тохиолдолд Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооноос ТУЗ-ийн гишүүний үйл ажиллагааны үнэлгээг зохион байгуулж, үнэлгээний дүгнэлт гаргасны үндсэн дээр улираан нэр дэвшүүлэх, эсхүл чөлөөлөх саналыг гаргана.
- 5.14. ТУЗ, Гүйцэтгэх удирдлагаас бусад эрх бүхий албан тушаалтанд нэр дэвших этгээд нь Журмын 3.1.3-т заасан хугацааны шаардлагыг хангаагүй ч Компанид тогтвортой суурьшилтай ажиллаж, мэдлэг ур, чадвар, харилцаа хандлагаараа манлайлж, үлгэр дуурайлал болж чадсан гэж үзвэл түүнийг эрх бүхий албан тушаалтанд нэр дэвшүүлж, сонгож болно.

**ЗУРГАА. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНЭЭС БУСАД КОМПАНИЙН
ЭРХ БУХИЙ АЛБАН ТУШААЛТНЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ, ТОМИЛОХ**

- 6.1. ТУЗ-ийн гишүүн болон нарийн бичгийн даргаас бусад Компанийн эрх бүхий албан тушаалтан (цаашид “Бусад эрх бүхий албан тушаалтан” гэх)-ы материалыг хүлээн авах, сонгон шалгаруулах, томилох бүрэн эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал, охин компанийн хувьд тухайн компанийн Гүйцэтгэх захирал эдлэх ба эрх бүхий албан тушаалтныг сонгон шалгаруулах, томилохтой холбоотой үйл ажиллагаанд ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо хяналт тавьж ажиллана.
- 6.2. Дээрх эрх бүхий албан тушаалтны сонгон шалгаруулалтыг энэхүү Журам болон компанийн дотоод сонгон шалгаруулалтын журмын дагуу Гүйцэтгэх захирал нь Хүний нөөцийн нэгжтэй хамтран зохион байгуулна.
- 6.3. Компанийн эрх бүхий албан тушаалтны сонгон шалгаруулалтад оролцохыг хүссэн этгээд нь тохиромжтой этгээд болохоо нотлон Журмын 4.1-т заасан баримт бичгийг бүрдүүлж, сонгон шалгаруулалт зарласан сувгаар ирүүлнэ.
- 6.4. Сонгон шалгаруулалтын эхний үе шатыг Компанийн Хүний нөөцийн нэгжээс хийх тохиолдолд нэгжийн удирдлага нь шаардлагатай баримт бичгийг хүлээн авч, эрх бүхий

- албан тушаалтны шаардлага хангаж байгаа эсэхийг шалгаж, шаардлага хангасан этгээдийг Гүйцэтгэх захиралд санал болгоно.
- 6.5. Журмын 6.4-т заасны дагуу Хүний нөөцийн нэгжээс санал болгож буй ажил горилогчдоос хамгийн сайн шаардлага хангаж байгаа этгээдийг эрх бүхий албан тушаалтнаар томилох шийдвэрийг Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг ТУЗ-д санал болгох шийвэрийг ТУЗ-ийн дарга гаргана.
- 6.6. Гүйцэтгэх захирал нь эрх бүхий албан тушаалтнаар сонгогдсон этгээдийн тухайн албан тушаалын тавигдах шаардлагыг хангаж байгаа эсэхийг үнэлж дүгнэх, ур чадвар болон харилцаа, хандлагыг тодорхойлох зорилгоор түүнийг 3 хүртэл сарын хугацаагаар томилж болно.
- 6.7. Хүний нөөцийн нэгжээс хийх сонгон шалгаруулалттай холбоотой нарийвчилсан харилцааг Компанийн дотоод сонгон шалгаруулалтын журмаар зохицуулна.

ДОЛОО. КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ҮҮРГИЙГ ХУГАЦААНААС ӨМНӨ ДУУСГАВАР БОЛГОХ

- 7.1. Эрх бүхий албан тушаалтныг анх томилсон эрх бүхий этгээд нь эрх бүхий албан тушаалтнаас хугацаанаас өмнө дараах үндэслэлээр дуусгавар болгож болно. Үнд:
- 7.1.1. Гүйцэтгэлийн тайлангаар хангалтгүй буюу 80% ба түүнээс бага үнэлгээ авсан ба сайжруулах төлөвлөгөө гарган ажилласан хэдий ч үр дүн гараагүй;
- 7.1.2. ТУЗ-ийн гишүүн нь тухайн санхүүгийн жилд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ТУЗ-ийн ээлжит хурлыг 2 ба түүнээс дээш удаа тасалсан эсхүл дараалан 3 ба түүнээс дээш удаа тасалсан;
- 7.1.3. Тухайн эрх бүхий албан тушаалтан нь ажил үүргээ гүйцэтгэх явцдаа тохиромжтой этгээдийн шаардлага хангахгүй болсон;
- 7.1.4. Анх нэр дэвишиж, сонгогдохдоо хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь Хорооны шалгалтаар тогтоогдсон;
- 7.1.5. Компанийн ёс зүйн дүрмийг ноцтой зөрчиж, ажил олгогч, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдын итгэлийг алдсан;
- 7.1.6. Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох дүрэм, журам болон Компанийн дүрэм, дотоод бодлого, журам, гэрээнд заасан эрх бүхий албан тушаалтны үүргээ 3 ба түүнээс дээш удаа зөрчсөн үйлдэл, эс үйлдэл гаргасан эсхүл үүргээ зөрчсөний улмаас Компанид хохирол учирсан;
- 7.1.7. Санхүүгийн зохицуулах хорооноос тохиромжтой этгээд бус гэж тооцсон;
- 7.1.8. Хууль тогтоомж болон эрх бүхий албан тушаалтантай байгуулсан гэрээнд заасан бусад үндэслэл.
- 7.2. Компанийн эрх бүхий албан тушаалтны үүргийг дуусгавар болгох шийдвэр гарсан тохиолдолд ажил хүлээлцэх акт үйлдэхээс өмнө шийдвэр гарсан өдрөөр тасалбар болгон ажлын гүйцэтгэлийн тайланг, холбогдох баримт бичгийн хамт хүргүүлнэ.

НАЙМ. КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫГ ТҮР ТОМИЛОХ, ЗАЛГАМЖ ХАЛААГ БЭЛДЭХ

- 8.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын түр эзгүйд түүний чиг үүргийг хэрэгжүүлэх этгээдийг ТУЗ-ийн гишүүд дотроос ТУЗ-ийн дарга сонгох ба хэрэв ийнхүү сонгоогүй тохиолдолд ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан этгээд ТУЗ-ийн даргын чиг үүргийг түр орлон гүйцэтгэнэ.

**КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫГ СОНГОН
ШАЛГАРУУЛАХ, НЭР ДЭВШҮҮЛЭХ, ТОМИЛОХ, ЧӨЛӨӨЛӨХ ЖУРАМ**

Т1-ТУЗ-02

- 8.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан, эсхүл нас барсан төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг орлох этгээдийг нөхөн сонгууль хүртэл Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны санал болгосноор ТУЗ түр томилж болно.
- 8.3. ТУЗ-ийн нарийн бичгийн даргын түр эзгүйд түүний ажлыг түр орлон Гүйцэтгэх этгээдийг ТУЗ-ийн дарга томилно.
- 8.4. Бусад эрх бүхий албан тушаалтан ажил үүргээ Гүйцэтгээгүй буюу Хөдөлмөрийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1-т заасан тохиолдолд тухайн албан тушаалтан нь ажилдаа эргэн орох хүртэл ажил үүргийг түр Гүйцэтгэх этгээдийг Гүйцэтгэх захирал түр томилж болно. /Хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгох тохиолдолд шинээр эрх бүхий албан тушаалтан томилогдох хүртэл нэгэн адил хамаарна./
- 8.5. Ондөр насны тэтгэвэрт гарах болон таамаглаж болохуйц сул орон тоонд шаардлага хангасан нэр дэвшигчийг урьдчилан тодорхойлохын тулд Хороо болон Гүйцэтгэх удирдлага нь жил бүрийн давтамжтайгаар судалгаа хийнэ.
- 8.6. Компанид тогтвортой суурьшилтай ажиллаж, мэдлэг ур, чадвар, харилцаа хандлагаараа манлайлж ажилласан ажилтнуудыг ирээдүйн эрх бүхий албан тушаалтны шаардлагад нийцүүлэн сургах, чадавхжуулах ажлыг Хороо болон Гүйцэтгэх удирдлага зохион байгуулж ажиллана.
- 8.7. Эрх бүхий албан тушаалтны сул орон тоог тухай бүр нөхөх зорилгоор шаардлага хангаж байгаа боловч сонгогдоогүй нэр дэвшигчийг эсхүл эрх бүхий албан тушаалтанд тохиромжтой гэж үзсэн этгээдийг дотоод хүний нөөц болон гаднаас тодорхойлж Хороо болон Гүйцэтгэх удирдлага нь тохиромжтой этгээдийн нөөцдөд бүртгэж, бүртгэл үүсгэнэ.
- 8.8. ТУЗ-ийн гишүүнд түр томилогдох гишүүн нь тохиромжтой этгээд байхаас гадна хараат бус гишүүний шаардлага хангасан байна. Бусад эрх бүхий албан тушаалд түр томилогдож байгаа этгээд нь тохиромжтой этгээдийн шаардлагыг мөн адил хангасан байна.

ЕС. ТОХИРОМЖТОЙ ЭТГЭЭДИЙН ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

- 9.1. Компанийн ТУЗ-ийн гишүүн болон нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх удирдлагыг тохиромжтой этгээдийн шаардлага хангаж байгаа эсэхэд болон энэхүү Журмын хэрэгжилтэд Хороо хяналт тавьж ажиллана.
- 9.2. Журмын 9.1-т зааснаас бусад эрх бүхий албан тушаалтан нь тохиромжтой этгээдийн шаардлага хангаж байгаа эсэхэд Компанийн гүйцэтгэх захирал хяналт тавьж ажиллах ба сонгон шалгаруулалт, томилолттой холбоотой Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаанд Хороо хяналт тавьж ажиллана.
- 9.3. Тохиромжтой этгээдийн шаардлага хангахгүй болсон нь тогтоогдсон эрх бүхий албан тушаалтныг ажлаас чөлөөлөх, өөр ажил, албан тушаалд шилжүүлэх эсэхийг анх томилсон эрх бүхий этгээд нь дариу шийдвэрлэнэ.
- 9.4. Энэхүү журмыг зөрчсон ажилтан, албан тушаалтанд Компанийн хөдөлмөрийн дотоод журамд заасан хариуцлага ногдуулна.

**КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫГ СОНГОН
ШАЛГАРУУЛАХ, НЭР ДЭВШҮҮЛЭХ, ТОМИЛОХ, ЧӨЛӨӨЛӨХ ЖУРАМ**

Т1-ТУЗ-02

- 9.5. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас Компани, хувьцаа эзэмшигч болон зээлдүүлэгчид учруулсан эдийн болон эдийн бус хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө. Үүнд:
- 9.5.1. Компанийн нэрийг хувийн сонирхлоор ашигласан;
 - 9.5.2. Өөрт олгогдсон эрх мэдлээ хэтрүүлэн буюу урвуулан ашигласан;
 - 9.5.3. Үнэт цаасны зах зээлд хориглох үйл ажиллагаа явуулсан;
 - 9.5.4. Энэхүү журам болон хууль тогтоомжид заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй.
- 9.6. Журмыг зөрчсөн үйлдэл нь эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэхээр бол зохих хууль, хяналтын байгууллагад шилжүүлж, шийдвэрлүүлнэ.

АРАВ. БУСАД

- 10.1. Энэхүү журам нь ТУЗ-ийн хуралд оролцож байгаа гишүүдийн дийлэнх олонхын саналаар батлагдах ба ТУЗ-ийн тогтоосон өдрөөс хучин төгөлдөр мөрдөгдөж эхлнэ.
- 10.2. Журамд нэмэлт өөрчлөлт оруулах эрхийг ТУЗ эдлэх бөгөөд тухайн нэмэлт өөрчлөлтийг оруулан баталснаар энэхүү журмын нэгэн адил даган мөрдөгднө.
- 10.3. Журамд тусгагдаагүй аливаа асуудлыг Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, зохицуулах байгууллага, Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас батлагдсан холбогдох дүрэм, журам, эрх зүйн хэм хэмжээнд зааснаар шийдвэрлэнэ.

АРВАН НЭГ. ХОЛБОГДОХ БАРИМТ БИЧГҮҮД

- 11.1. Энэхүү баримт бичигтэй холбогдох бусад баримт бичгүүд
 - 11.1.1. Компанийн дүрэм;
 - 11.1.2. Хөдөлмөрийн дотоод журам;
 - 11.1.3. Компанийн албан хэрэг хөтлөлтийн багц журам;
 - 11.1.4. ТУЗ-ийн үйл ажиллагааны журам;
 - 11.1.5. ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллаганы журам;
 - 11.1.6. Гүйцэтгэлийн үнэлгээний журам;
 - 11.1.7. Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам.
- 11.2. Энэхүү баримт бичгийн хавсралтууд:

№	Хавсралтын нэр	Дугаар
1	Баталгаа (ТУЗ-ийн хараат бус гишүүдээс бусад эрх бүхий албан тушаалтан)	Хавсралт №1
2	Баталгаа (ТУЗ-ийн хараат бус гишүүн)	Хавсралт №2
3	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийн анкет	Хавсралт №3
4	Нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдэгдэл	Хавсралт №4

-----oOo-----